



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

Г "Субуд" ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох, Г
төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам"-ын 1.2, 1.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Субуд" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг "Субуд" ХЗХ /О.Гарам/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000702